



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/24

Мөрөн сум

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8 дугаар багт хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан гадна цахилгаан хангамжийн ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Ж.Нацагдорж (Онцгой байдлын газрын Гал түймрийн хяналтын улсын байцаагч, Хошууч)

Д.Аюуш (Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн Ашиглалтын албаны дарга)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Ц.Шүрэнцэцэг ("Креатив энерги инженеринг" ХХК-ийн Ерөнхий инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Г.Даваасүрэн ("Зоост хайрхан" ХХК-ийн захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Н.Пүрэвдорж ("Наран гүрт" ХХК-ийн захирал)

Комиссын нарийн бичгийн дарга:

Э.Аззаяа (Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)

2. Барилга байгууламжийг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээллэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

Захирамж-2023


6717010017

2.

3. Барилга байгууламжийг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Э.Азжая) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ш.ИДЭРБАЯСГАЛАН